



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 1/198

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын Хавсралт 9 “Үйл ажиллагааг хялбарчлах”-ийн 3.61-3.67 дахь стандартыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Агаарын хөлгийн “Нисэх багийн гишүүний гэрчилгээ олголтод хяналт тавих журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Нисэх багийн гишүүний гэрчилгээний өргөдлийн маяг”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг хэрэгжүүлж, мөрдөн ажиллахыг Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын алба (П.Ганболд)-нд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА

Иргэний нисэхийн ерөнхий газрын
даргын 2023 оны 07 дугаар сарын 06 ны
өдрийн 11 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт

НИСЭХ БАГИЙН ГИШҮҮНИЙ ГЭРЧИЛГЭЭ ОЛГОЛТОД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

1. Эрх зүйн үндэс

1.1 “Нисэх багийн гишүүний гэрчилгээ олголтод хяналт тавих журам”-ыг Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын Хавсралт 9 “Хялбаршуулах”, ICAO Document 9303 “Машинаар уншигдах аяллын баримт бичиг”-ын стандарт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 137 дугаар тогтоолоор батлагдсан “Агаарын тээврийг хялбаршуулах журам” болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн боловсруулсан болно.

2. Нэр томьёо

2.1 Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1 “нисэх багийн гишүүний гэрчилгээ” /цаашид НБГГ гэх/ гэж нисэх багийн гишүүдийг улсын хилийн цахим гарцаар нэвтрэхэд шаардагдах аяллын баримт бичгийг;

2.1.2 “агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ” гэж

2.1.2.1 ИНД-119 /Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт/ болон ИНД-135 /Нисдэг тэрэг болон жижиг нисэх онгоцны арилжааны нислэгийн үйл ажиллагаа/-ын хувьд, шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ, эсхүл ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг; эсхүл

2.1.2.2 ИНД-121 /Том нисэх онгоцны арилжааны нислэгийн үйл ажиллагаа/ болон ИНД-125 /Дунд нисэх онгоцны арилжааны нислэгийн үйл ажиллагаа/-ын хувьд, шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг;

2.1.3 “нисэх багийн гишүүн” гэж нислэгийн хугацаанд агаарын хөлөгт үүрэг гүйцэтгүүлэхээр агаарын тээвэрлэгчээс томилсон этгээдийг.

3. Зорилго

3.1 Энэхүү журмын зорилго нь 1.1-д дурдсан эрх зүйн баримт бичгийн хүрээнд НБГГ-г тохирох зөв хүнд олгоход тавигдах шаардлага, хяналт, эрх үүрэг, хариуцлагыг тогтооход оршино.

3.2 Иргэний нисэхийн ерөнхий газар /цаашид “Ерөнхий газар” гэх/ нь НБГГ-г тохирох зөв хүнд олгоход хяналт тавих үүрэгтэй.

3.3 Агаарын тээвэрлэгч нь НБГГ-г хэвлэх, ашиглах, бүртгэлжүүлэх үүрэгтэй бөгөөд энэхүү журамд заасан аливаа нөхцөлийг дагаж мөрдөнө.

3.4 НБГГ-г олон улсын нислэгт үүрэг гүйцэтгэж буй нисэх багийн гишүүдийг хүлээн авах улсаас зөвшөөрсөн түр хугацаанд визгүй нэвтрэх зорилгоор олгох бөгөөд уг гэрчилгээ нь гадаад паспортын хамт хүчин төгөлдөр болно.

4. Хамрах хүрээ

4.1 Нислэгийн хугацаанд агаарын хөлөгт үүрэг гүйцэтгэх дараах ажилтнууд НБГГ авах хүсэлт гаргана. Үүнд:

4.1.1 нисэх багийн гишүүн;

4.1.2 бүхээгийн ажилтан;

4.1.3 нислэгийн диспатчер;

4.1.4 агаарын хөлгийн ачаалал хяналтын ажилтан /агаарын хөлгийн ачаалал төлөвлөлтийн ажилтан;

4.1.5 агаарын хөлгийн засвар үйлчилгээний ажилтан;

4.1.6 нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч;

4.1.7 нислэгийн үед тусгай үүрэг гүйцэтгэж буй бусад ажилтнууд.

5. НБГГ олгоход тавих шаардлага

5.1 НБГГ олгоход дараах баримт бичгийг шаардана. Үүнд:

5.1.1 Өргөдөл гаргагч нь тухайн байгууллагад ажилладаг болон заасан албан тушаалын шаардлагыг хангасан гэдгийг тодорхойлсон агаарын тээвэрлэгч байгууллагын албан хүсэлт;

5.1.2 Зохих ёсоор бөглөсөн НБГГ хүсэх өргөдлийн маягт;

5.1.3 Хүчинтэй гадаад паспортын хуулбар;

5.1.4 Үнэмлэхийн зураг;

5.1.5 Иргэний үнэмлэхийн хуулбар;

5.1.6 Ажлын газрын үнэмлэхийн хуулбар;

5.1.7 НБГГ-г сунгах тохиолдолд хугацаа дууссан гэрчилгээ.

5.2 Өргөдөл гаргагч нь Хавсралт 2-д үзүүлсний дагуу НБГГ-ний өргөдлийн маягыг бөглөнө.

5.3 НБГГ олгох ажилтанд дараах техникийн шаардлагыг тавина.

5.3.1 Нисэх багийн гишүүн

- маягийн зэрэглэлийн хүчинтэй гэрчилгээ бүхий нисгэгчийн үнэмлэхтэй байх;

- эрүүл мэндийн хүчинтэй гэрчилгээтэй байх.

5.3.2 Бүхээгийн ажилтан

- агаарын тээвэрлэгчээс олгосон бүхээгийн ажилтны хүчин төгөлдөр гэрчилгээтэй байх;
- эрүүл мэндийн хүчинтэй гэрчилгээтэй байх.

5.3.3 Нислэгийн диспатчер

- нислэгийн диспатчерийн сургалтад хамрагдсан гэрчилгээтэй байх;
- агаарын тээвэрлэгчээс үйл ажиллагаа явуулах эрх олгосон зөвшөөрөлтэй байх.

5.3.4 Агаарын хөлгийн ачаалал хяналтын ажилтан /Load controller/

- ачаалал хяналтын үйл ажиллагааны гадаад болон дотоодын сургалтад хамрагдсан байх;
- зорчигч тээврийн агаарын хөлгийн маягт тохирох ачаалал төлөвлөлт хийх зөвшөөрөлтэй байх.

5.3.5 Агаарын хөлгийн ачаалал төлөвлөлтийн ажилтан /Load master/

- ачаалал төлөвлөлтийн мэргэшүүлэх гадаад болон дотоодын сургалтад хамрагдсан байх;
- зорчигч тээврийн агаарын хөлгийн маягт тохирох ачаалал төлөвлөлт хийх зөвшөөрөлтэй байх.

5.3.6 Агаарын хөлгийн засвар үйлчилгээний ажилтан

- ИНД-ийн дагуу холбогдох агаарын хөлгийн зэрэглэлээр батлагдсан агаарын хөлгийн засвар үйлчилгээний ажилтны хүчинтэй үнэмлэхтэй байх (AMEL).

5.3.7 Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч

- ИНД-ийн дагуу холбогдох чиглэлээр гэрчилгээжсэн үнэмлэхтэй байх;

5.4 НБГГ-г баталгаажуулах үйл явц нь Ерөнхий газраас тавьсан шаардлагад нийцсэн байх бөгөөд гэрчилгээ олгохоос өмнө тухайн ажилтны анкет шалгалт болон ажил эрхлэлтийн байдлыг шалгасан байна.

6. НБГГ-ний загвар

6.1. НБГГ-г ICAO Document 9303 “Машинаар уншигдах аяллын баримт бичиг”-ийн 5 дахь хэсэгт заасан стандартад нийцүүлэн хэвлэнэ.

7. Хяналтын үйл ажиллагаа

7.1. Ерөнхий газар нь агаарын тээвэрлэгчийн НБГГ-г олгох үйл ажиллагаанд дараах хяналтыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

7.1.1. гэрчилгээ олголт, түүнд тавих хяналтыг гүйцэтгэхэд холбоотой бүртгэл, өгөгдөл болон бусад материалыг шалгах;

7.1.2. бүртгэл, өгөгдөл болон бусад материалын шаардлагатай хувь, эсхүл хуулбарыг авах;

7.1.3. НБГГ хүсэж буй өргөдөл гаргагчаас тайлбар авах;

7.1.4. Агаарын тээвэрлэгчээс ирүүлсэн НБГГ олгох өргөдлийн маягтыг хянаж,

тохирох зөв хүнд олгох зөвшөөрлийг агаарын тээвэрлэгчид албан бичгээр эсхүл цахим шуудангаар өгнө.

7.1.5. холбогдох байгууламж болон үйл ажиллагааны бүсэд нэвтрэх;

7.1.6. аудит, шинжлэн шалгалт, үнэлгээ, үзлэг шалгалт болон гэнэтийн шалгалтыг хийж гүйцэтгэх;

7.1.7. зохих албадлагын арга хэмжээ авах.

8. Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн үүрэг

8.1. Агаарын тээвэрлэгч нь НБГГ олгох зөвшөөрлийг авахдаа энэхүү журмын 2 дугаар хавсралтаар батлагдсан НБГГ-ийн өргөдлийн маягыг бөглөж, Ерөнхий газарт ирүүлнэ.

8.2. Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь НБГГ олгох, баримт бичгийн аюулгүй байдлыг хангах талаар хяналт тогтоох журамтай байна. Журамд дараах зохицуулалтыг тусгана. Үүнд:

8.2.1. НБГГ-г хэвлэлтэд өгөхөөс өмнө гэрчилгээ дээрх хувийн мэдээллийг хянах, шаардлагатай тохиолдолд өөрчлөлт оруулах;

8.2.2. Түдгэлзүүлсэн, хураагдсан, хүчинтэй хугацаа дууссан НБГГ-г бүртгэж, устгалд оруулна. Эдгээр бичиг баримтыг зөвшөөрөлгүй хүн нэвтрэх боломжгүй нөхцөлд аюулгүй байдлыг нь хангаж, цахим хэлбэрээр хадгалах;

8.2.3. Цахим мэдээллийн санд хадгалагдсан хувийн мэдээллийг НБГГ олгохоос бусад зорилгоор ашиглахыг хориглох;

8.2.4. НБГГ-ний картын бэлдцийг жагсаалтад заагдсан зөвхөн эрх бүхий ажилтан нэвтрэх газар хадгалах;

8.2.5. Хэвлэлтийн алдаа болон ашигласан хоосон картуудыг үнэт цаасны хяналтын баримт бичигт бүртгэж, зохих засвар оруулах.

8.3. Агаарын тээвэрлэгч нь НБГГ-г хуурамчаар хэвлэх боломжийг хязгаарлах зорилгоор уг гэрчилгээг олгох эрх бүхий ажилтнуудын жагсаалтыг гаргаж баталгаажуулсан байна.

8.4. Агаарын тээвэрлэгч нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- анкет шалгалт хийх;

- НБГГ олгох үүрэг бүхий ажилтны буруугаас алдаатай гэрчилгээ олгогдсон тохиолдолд хуулийн болон захиргааны хариуцлага хүлээх.

8.4 НБГГ-г хэвлэх байгууллагатай хариуцлагын гэрээ байгуулах ба уг байгууллагад Ерөнхий газраас үе шаттайгаар хяналт тавихад шаардлагатай нөхцөлийг бүрдүүлсэн байна.

8.5 НБГГ-г 3 жил хүртэл хугацаагаар олгоно.

8.5. НБГГ эзэмшигч нь зөвхөн олон улсын нислэгт үүрэг гүйцэтгэх үедээ хүчин төгөлдөр бүхий НБГГ-г гадаад паспортын хамт биедээ авч явах үүрэгтэй.

9. Хүчин төгөлдөр болох

9.1. Энэхүү журмыг Ерөнхий газрын дарга баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөнө.

9.2. Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын Хавсралт 9 “Хялбаршуулах”, ICAO Document 9303 “Машинаар уншигдах аяллын баримт бичиг” болон “Агаарын тээврийг хялбаршуулах журам” зэрэг баримт бичгүүдэд орсон холбогдох нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр энэхүү журамд тусгана.

10. Хариуцлага

10.1. Энэхүү журмыг зөрчсөн оролцогч талуудад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага тооцно.

--- оОо ---

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2023 оны 07 дугаар сарын 06 ны өдрийн А/198
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Нисэх багийн гишүүний гэрчилгээний өргөдлийн маягт

<input type="checkbox"/> Олгох	<input type="checkbox"/> Шинэчлэх	<input type="checkbox"/> Дахин олгох	<input type="checkbox"/> Дэлгэрэнгүй мэдээллийг өөрчлөх	Зураг Хэмжээ 35.0 x 45.0
<input type="checkbox"/> Нисэх баг	<input type="checkbox"/> Бүхээгийн баг		<input type="checkbox"/> Агаарын хөлгийн засвар үйлчилгээний ажилтан	
<input type="checkbox"/> Агаарын хөлгийн ачаалал хяналтын ажилтан		<input type="checkbox"/> Нислэгийн диспатчер		
<input type="checkbox"/> Агаарын хөлгийн ачаалал төлөвлөлтийн ажилтан				
<input type="checkbox"/> Бусад ажилтан – нислэгийн үед тусгай үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай бусад ажилтнууд.				
Тухайн ажилтны албан тушаалыг тодорхой бичнэ үү				
Тэмдэглэл:				
1. Маягтыг сайтар уншиж, зөвхөн тохирох хэсгийг бөглөнө үү.				
2. Маягтыг ТОМ ҮСГЭЭР, эсхүл чагтлах хайрцгаас <input type="checkbox"/> сонголт хийж бөглөнө.				
Бөглөх хэсгүүд (өөрт хамаарах хэсгийг бүрэн бөглөх шаардлагатай)				
<input type="checkbox"/> Олгох (хэсэг 1 ба 3)		<input type="checkbox"/> Шинэчлэх (хэсэг 1 ба 3)		
<input type="checkbox"/> Дахин олгох (хэсэг 1, 3, 5)		<input type="checkbox"/> Дэлгэрэнгүй мэдээллийг өөрчлөх/засварлах (хэсэг 1,2, болон 3)		
Хэсэг 1. Өргөдөл гаргагчийн хувийн мэдээлэл				
<u>Паспорт</u> дээрх нэр	Овог:		Өөрийн нэр:	
Ажил олгогчийн нэр:		Холбоо барих дугаар:	утасны	Хүйс: <input type="checkbox"/> эмэгтэй <input type="checkbox"/> Эрэгтэй
НБГГ дугаар:		Ажилтны дугаар.		
Томилгоо		Паспортын дугаар		
Иргэншил		Паспортын хүчинтэй хугацаа		
Төрсөн огноо		Оршин суух үнэмлэхний дугаар & хүчинтэй хугацаа		
Хэсэг 2. Дэлгэрэнгүй өөрчлөлт/засвар				
	Өмнөх	Одоо		
Нэр өөрчлөгдөх				
Иргэний харьяаллыг өөрчлөгдөх				
Ажил мэргэжлийн өөрчлөлт				

Паспортын дэлгэрэнгүй мэдээлэл өөрчлөгдөх		
Бусад		

Хэсэг 3. Баримт бичигт тавигдах ерөнхий шаардлага

А. Анх олгох/Шинэчлэх/Дахин олгох/Өөрчлөх

1.	Өргөдөл гаргагчийн тухайн албан тушаалд мэргэшсэн гэдгийг баталгаажуулсан агаарын тээвэрлэгчийн албан бичиг	5.	Иргэний үнэмлэхийн хуулбар
2.	НБГГ-ний бөглөсөн өргөдлийн маягт No.01	6.	Сүүлийн үеийн үнэмлэхийн зураг (дээр дурдсан техникийн үзүүлэлтүүдийг хангасан)
3.	Хувийн мэдээллийг харуулсан паспортын хуулбар	7.	Хүчинтэй хугацаа нь дууссан НБГГ (Шинэчлэх)
4.	Ажилтны үнэмлэхийн хуулбар		

Б. Нисэх багийн гишүүдийн нэмэлт бичиг баримт бүрдүүлэх шаардлага-Олгох болон шинэчлэх

1.	Маягийн зэрэглэлийн хүчинтэй гэрчилгээ бүхий нисгэгчийн үнэмлэх	Нисэх баг
2.	Хүчин төгөлдөр ур чадварын үнэмлэх	Бүхээгийн баг
3.	Хүчин төгөлдөр эрүүл мэндийн гэрчилгээний хуулбар	Нисэх баг ба бүхээгийн баг
4.	Агаарын хөлгийн зэрэглэлээр батлагдсан агаарын хөлгийн засвар үйлчилгээний ажилтны хүчинтэй үнэмлэх	Агаарын хөлгийн засвар үйлчилгээний ажилтан

Тэмдэглэл: Шинээр дадлагажигч НБГГ анх авахаар өргөдөл гаргаж байгаа бол 1 ба 2-р зүйлд заасан баримт бичгийг шаардахгүй.

Г. Нисэх багийн гишүүдийн нэмэлт баримт бичгийн шаардлага - анхны олголт

1.	Ачаалал хяналтын үйл ажиллагааны гадаад болон дотоодын сургалтад хамрагдсан гэрчилгээ	Агаарын хөлгийн ачаалал хяналтын ажилтан
2.	Агаарын тээвэрлэгчээс олгосон тодорхой үйл ажиллагааны чиг үүрэг/агаарын хөлөг дээр ажиллах зөвшөөрөл	Агаарын хөлгийн ачаалал тооцоологч
3.	Ачаалал төлөвлөлтийн мэргэшүүлэх гадаад болон дотоодын сургалтад хамрагдсан гэрчилгээ	Агаарын хөлгийн ачаалал төлөвлөлтийн ажилтан
4.	Агаарын хөлгийн маягт тохирох ачаалал төлөвлөлт хийх агаарын тээвэрлэгчээс олгосон зөвшөөрөл	Агаарын хөлгийн ачаалал төлөвлөлтийн ажилтан
5.	Нислэгийн диспатчерийн сургалтын гэрчилгээ	Нислэгийн диспатчер
6.	Агаарын тээвэрлэгчээс үйл ажиллагаа явуулах эрх олгосон зөвшөөрөл	Нислэгийн диспатчер
7.	Агаарын тээвэрлэгчээс томилогдсон нислэгийн үед тодорхой үүрэг гүйцэтгэх мэргэшсэн ажилтны сургалтын гэрчилгээний хуулбар	Агаарын тээвэрлэгчийн удирдах албан тушаалтнууд

Хэсэг 4. Нэр дэвшүүлсэн хүний баталгаа

Би өргөдөл гаргагч нь _____-ийн ажилтан, өргөдөлдөө дэлгэрэнгүй дурдсан албан тушаалд тэнцэх, НБГГ-нд тавигдах ИНЕГ-ын шаардлагыг хангасан гэдгийг үүгээр баталж байна.

Нэр дэвшүүлсэн хүний нэр _____ гарын үсэг _____

Огноо: _____ (өдөр/сар/он)

Хэсэг 5. Дахин олгох (Алдагдсан, Хулгайлагдсан, Гэмтсэн)

Алдагдсан, хулгайлагдсан, гэмтсэн НБГГ олгох нөхцөл:

Жич: Нисэх багийн гишүүний гэрчилгээ алдагдсан, хулгайлагдсан тохиолдолд зарлуулсан маягтыг хавсаргана уу.

Тэмдэглэл: Өргөдөл гаргагчийн итгэмжлэлийг баталгаажуулсан албан ёсны баримт бичгийг хавсаргана (боломжтой бол).

Өргөдөл гаргагчийн гарын үсэг _____

Зөвхөн ИНЕГ-ын хэрэглээнд зориулагдсан

Баримт бичгүүд хүчинтэй бөгөөд бүрдсэн

Өргөдөл Зөвшөөрсөн Татгалзсан

Тайлбар (хэрэв байгаа бол)

Олгох огноо:

Хүчин төгөлдөр байх хугацаа:

Олгосон байгууллага:

Нэр, гарын үсэг: Огноо: